


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЛУУС СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 1/23

Цагаан-Овоо

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Дундговь аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 30 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. “Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд сумын Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, хүүхэд тус бүр олимпиадад оролцож багаар хамтран ажиллах мэдлэг, чадварыг дээшлүүлэх, сургалтын ахиц амжилтыг нэмэгдүүлэх чиглэлээр 3,4,6,7,8,9 дүгээр ангиудад массын олимпиадыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганчимэг (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Сайнтуяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд: Б.Цэрмаа (Хөдөлмөр эрхлэлт халамжийн

асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э.Сумьяажаргал (Нягтлан бодогч)

Х.Адъяасүрэн (1-р багийн засаг дарга)

О.Цэвэгмэд (Архив бичиг хэргийн ажилтан)

Ш.Отгонжаргал (Ерөнхий боловсролын

сургуулийн сургалтын менежер)

2. Анги нийтийн олимпиадыг удирдамжийн дагуу хяналт тавьж мэдээ тайланг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт хугацаанд нь хүргэж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганчимэг), нарийн бичгийн дарга (Б.Сайнтуяа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.Өлзийхишиг

